



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/734

Улаанбаатар хот

Хилийн нэвтрэх цэгт коронавируст  
халдвар (КОВИД-19)-ын тандалтыг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13, 8.1.24 дэх заалт, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Улсын Онцгой Комиссын 2021 оны 29 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаад улсаас ирсэн Монгол Улсын болон гадаад улсын 4-11 насны хүүхдээс ам залгиур, 11-ээс дээш насны хүнээс хамар залгиурын арчдас авч, хилийн нэвтрэх цэгт SARS-CoV-2 вирусийн антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээнд хамруулах, бодит хугацааны полимерадын гинжин урвалын шинжилгээнд сорьц авах ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Түргэвчилсэн болон бодит хугацааны полимерадын гинжин урвалын шинжилгээний хариу сөрөг гарсан иргэдийг 10 хоногийн хугацаанд гэрийн ажиглалтад шилжүүлж, эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийх, 4 дэх өдөр бодит хугацааны полимерадын гинжин урвалын шинжилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Бодит хугацааны полимерадын гинжин урвалын шинжилгээний хариу эерэг гарсан иргэдийн мэдээллийг tandalt.gov.mn цахим программд оруулж, эмнэлэгт тусгаарлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, хавьтлыг тогтоон, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. SARS-CoV-2 вирусийн Омикрон хувилбарыг илрүүлэх, тандах зорилгоор бүх эерэг сорьцыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

5. SARS-CoV-2 вирусийн Омикрон хувилбарыг лабораториор тандан судлах, уг хувилбар бүртгэгдсэн улс орны жагсаалтыг өдөр тутам шинэчлэн гаргаж, Эрүүл мэндийн яам, олон нийтэд хүргэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д даалгасугай.

141213226

6. SARS-CoV-2 вирусийн Омикрон хувилбар илэрсэн улс орноос ирсэн, дамжин өнгөрсөн өгүүлэмжтэйгээр тусгаарлан ажиглах байранд шилжсэн иргэнийг тусгаарлалтын 4, 8 дахь өдөрт бодит хугацааны полимеразын гинжин урвалын шинжилгээнд хамруулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хэрэгцээнд шаардагдах түргэвчилсэн оношлуур, хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Б.Буянтогтох/, хүний нөөцийг дайчлах, холбогдох зардлыг шийдвэрлэж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/, Санхүү, эдийн засгийн газар /Т.Мөнхтуул/-т тус тус даалгасугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД